



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД (ТӨВ)-ИЙН
БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ЧИГ ҮҮРГИЙН
ДАВХЦАЛ, ҮР НӨЛӨӨ**

АУДИТЫН КОД: / НАГ-2026/22 -ШТА-НА /

Дундговь аймаг 2026 он

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын Дарга, тэргүүлэх аудитор:
Р.Мөнхтогтох
Утас: 7059-2439
Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 7059-2225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Ихбаяр
Аудитор: Г.Үүрийнтуяа
Аудитор: Э.Пүрэвбаатар

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Агуулга	
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгс	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын багийн бүрэлдэхүүн, аудитын дүн, үндсэн мэдээлэл	4-6
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	Тайлан баталгаажуулсан тушаал	7
	Дүрслэлийн товчъёг	8
Аудитын менежер Т.Батсайхан	<u>БҮЛЭГ : 1. Аймаг, сүмийн ИТХ-аас ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, засаглалын талаар хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалт нь холбогдох хууль, журмын шаардлагад нийцэж байна.</u>	9-12
Ахлах аудитор Д.Ихбаяр Аудитор Г.Үүрийнтуяа Э.Пүрэвбаатар	<u>БҮЛЭГ : 2. ОНӨААТҮГ-үүд нь чиг үүргээ хэрэгжүүлэн орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа боловч засаглал, санхүүгийн тогтвортой байдал хангалтгүйгээс үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө бүрэн хангагдахгүй байна.</u>	13-20
	Дүгнэлт	21
	Зөвлөмж	22
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70593208 дугаарын факсаар харилцана уу.	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	23
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот 2026 оны 9 дүгээр сар	Хавсралт	24

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
ХЭГ	Хэрэг эрхлэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СЯ	Сангийн яам
ШТА	Шууд тайлагнах ажил
НА	Нийцлийн аудит

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 оны аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу “Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төв)-ийн болон Төрийн байгууллага хоорондын чиг үүргийн давхцал, үр нөлөө”-д ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төв)-ийн болон Төрийн байгууллага хоорондын чиг үүргийн давхцал, үр нөлөө”-нд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.

Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр нөлөөтэй эсэх;
- Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд зорилго, чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаа нь үр дүнтэй, үр нөлөөтэй эсэх

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Төрийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компанийн тухай хууль,
- Засгийн газрын тогтоолууд,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол
- Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, харьяа газар, Дундговь-Ус ОНӨААТҮГ, Мандалын гэгээ хот тохижуулах газар, Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ, Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв, Мөнх эрин ногоон говь ОНӨААТҮГ газруудын зорилго, зорилт, чиг үүрэг, төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалыг хамруулж бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөө, хууль журмын нийцэлд хяналт үнэлгээ хийлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Т.Батсайхан үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Г.Үүрийнтуяа, Э.Пүрэвбаатар нар 2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 2026 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Аудитаар нийт 5,241.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгуулахаар 329.5 сая төгрөгийн 1 албан шаардлага, аймгийн Засаг дарга болон ОНӨААТҮГ болон тэдгээрийн ТУЗ-д 7 заалт бүхий 4,912.1 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

**ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ**

Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэдэг нь орон нутгийн (аймаг, нийслэл, сум, дүүрэг) өмч хөрөнгийг бүрэн болон хэсэгчлэн ашиглаж, хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулсан аж ахуйн тооцоот үйлдвэр, компани болон бусад байгууллагыг хэлнэ.

Эдгээр хуулийн этгээдийн өмчлөл болон удирдлагын онцлогийг дараах байдлаар ангилж байна.:

- Орон нутгийн өмчит хуулийн этгээд: Тухайн хуулийн этгээдийн нийт хувьцаа, хөрөнгийн 100 хувь нь орон нутгийн өмчид байх
- Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд: Хуулийн этгээдийн нийт хувьцаа, хөрөнгийн тодорхой хувийг (51 хувиас доош байж болно) орон нутаг, үлдсэн хувийг хувийн хэвшил болон бусад этгээд хамтран эзэмших

Дундговь аймагт 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 5 орон нутгийн өмчит хуулийн этгээд байна. Үүнд:

- Дундговь-Ус ОНӨААТҮГ
- Мандалын гэгээ хот тохижуулах газар ОНӨААТҮГ
- Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ
- Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв ОНӨААТҮГ
- Мөнх эрин ногоон говь ОНӨААТҮГ

Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бүртгэгдээгүй байна.



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 13/30

Мондговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралт батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1, 3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төв)-ийн болон Төрийн байгууллага хоорондын чиг үүргийн давхцал, үр нөлөө”-д хийсэн нийцлийн аудитын тайлан (НАГ-2026/20-10/ШТА-НА)-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төв)-ийн болон Төрийн байгууллага хоорондын чиг үүргийн давхцал, үр нөлөө”-д хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар заасан хугацаанд Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2027 оны 1 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор (Д.Ихбаяр)-г үүрэг болгосугай

Р.МӨНХТОГТОХ

4826010066

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНӨААТҮГ-уудыг үүсгэн байгуулсан шийдвэрийн мэдээлэл	9
Хүснэгт 2	ОНӨААТҮГ-уудын нийт орлого, санхүүжилтийн харьцааны мэдээлэл	15-16
Хүснэгт 3	Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын өр төлбөрийн мэдээлэл	17
Хүснэгт 4	Дундговь- Ус ОНӨААТҮГ-ын санхүүгийн шинжилгээ	18

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Аймгийн ОНӨААТҮГ-уудын нийт орлого, санхүүжилтийн харьцаа	15
График 2	Аймгийн ОНӨААТҮГ-уудын ашиг, алдагдал	16
График 3	Аймгийн ОНӨААТҮГ-уудын богино хугацаат өр, төлбөр	16



БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИТХ-ААС ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗАСАГЛАЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙНА.

1.1. “Мөнх эрин ногоон говь” ОНӨААТҮГ-ыг орон нутгийн өмчийн оролцоог бүрдүүлэхгүйгээр байгуулсан нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцээгүй байна.

ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулах, эд хөрөнгө өмчлөх, ашиглах эрхийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТУЗ болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцаа Компанийн тухай хуулиар зохицуулагдаж байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2026 оны байдлаар 5 ОНӨААТҮГ үйл ажиллагаагаа явуулж байна. Уг ОНӨААТҮГ-уудыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4²-т заасныг үндэслэн аймаг болон сумдын ИТХ-ын тогтоолоор үүсгэн байгуулж, шийдвэрийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг авсан байна.

Хүснэгт № 1 /ОНӨААТҮГ-уудыг үүсгэн байгуулсан шийдвэрийн мэдээлэл/

сая төгрөг

№	Шалгагдагч байгууллагын нэр	Үүсгэн байгуулсан огноо	Үүсгэн байгуулах шийдвэр, дугаар	Үүсгэн байгуулсан шийдвэр үндэслэлтэй эсэх	Үүсгэн байгуулахад эзэмшүүлсэн хөрөнгийн сан
1	Дундговь-Ус ОНӨААТҮГ	2005.07.01	АИТХ-ын 01 тогтоол	Тийм	6.7
2	Мандалын гэгээ хот тохижуулах газар ОНӨААТҮГ	2022.12.05	АИТХ-ын 73 тогтоол	Тийм	12,845.4
3	Дэрэн сумын Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ	2014.05.14	АИТХ-ын 34 тогтоол	Тийм	526.4
4	Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв ОНӨААТҮГ	2023.12.04	АИТХ-ын 79 тогтоол	Тийм	0.4
5	Мөнх эрин ногоон говь ОНӨААТҮГ	2025.01.23	Хулд сумын ИТХ-ын 03/01 тогтоол	Үгүй	-

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ, “Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ, “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ-уудыг байгуулсан аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн өмчийн хөрөнгийг тус байгууллагуудад шилжүүлж, өөрт олгогдсон хөрөнгийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах боломж нь бүрдсэн байна.

Харин “Мөнх эрин ногоон говь” ОНӨААТҮГ нь Хулд сумын ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 03/01 дугаар тогтоолоор байгуулагдаж, байгууллагын дүрэм болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Гэвч тухайн үүсгэн байгуулах шийдвэрт орон

¹ орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

² орон нутгийн өмчийн хуулийн зохицуулалт, өөрчлөх, татан буулгах шийдвэр гаргах, гүйцэтгэлд хяналт тавих.

нутгын өмчөөс эд хөрөнгө хөрөнгө шилжүүлэх талаар тусгаагүй, өмч хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлж шийдвэрлээгүй байна. *Хүснэгт № 1*

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1³, 15.2⁴-дэх заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд тус байгууллагыг өмчийн оролцоотой хуулийн этгээд болон аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үндсэн шинж, шаардлагад нийцүүлэн байгуулсан гэж үзэх боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байх, тухайн байгууллага шаардлагатай өмч хөрөнгийн эх үүсвэргүйгээр хэвийн үйл ажиллагаа явуулах, өөрийн орлогоор үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлэх боломж хязгаарлагдах эрсдэл үүссэн байна.

Иймд Мөнх эрин ногоон говь ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүүгийн бие даасан байдлыг хангах зорилгоор хуульд нийцүүлэн шаардлагатай эд хөрөнгийг орон нутгийн өмчөөс шилжүүлэн эзэмшүүлэх, орон нутгийн өмчийн хувь оролцоог бодитоор бүрдүүлэх, өмчийн бүртгэлд тусган баталгаажуулах талаар Хулд сумын Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аймгийн ИТХ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.12⁵-т заасныг үндэслэн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 5 ОНӨААТҮГ-ын үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэлийн дагуу байгууллагуудын дүрмийг боловсруулж баталсан байна.

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ, “Мандлын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ болон “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ-уудын ТУЗ байгууллагын дүрэмд заасан эрх үүргийн дагуу бүтэц, орон тоог үндсэн чиг үүргийн хүрээнд тодорхойлон тогтоосон байна. Эдгээр байгууллагууд нь батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа нь бүтэц, зохион байгуулалт нь байгууллагын зорилго, чиг үүрэгтэй уялдсан гэж үзэж байна.

Харин “Мөнх эрин ногоон говь” ОНӨААТҮГ нь Хулд сумын хог хаягдлын үйлчилгээ гудамж талбайн гэрэлтүүлэг цэвэрлэгээ хийх, ногоон байгууламжийн ашиглалт, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт хийх чиглэлээр 2025 онд байгуулагдсан. Гэвч ТУЗ-өөс байгууллагын дүрэмд заасан байгууллагын бүтэц, орон тоо, цалингийн сан, бизнес төлөвлөгөөг батлаагүй эрх үүргээ хэрэгжүүлээгүй байна. Мөн үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хөрөнгөөр хангагдаагүй учир 2025 онд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжийн хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулж 2026 онд огт үйл ажиллагаа эрхлээгүй байна.

“Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын 2014 оны 158 дугаар тогтоолоор бэлчээр, тэжээлийн ургамал тариалах, байгаль орчин, экологи, хөдөө аж ахуйн чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны үйл ажиллагаа эрхлэх, мөн төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран ажиллах зорилгоор байгуулсан байна. Гэвч улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлийг говийн нөхцөлд ургамал тариалах, малын тэжээл үйлдвэрлэх, энэ талаар малчид, иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах гэж бүртгэсэн нь үүсгэн байгуулах шийдвэрээр тогтоосон зорилго, чиг үүрэгтэй нийцээгүй, үйл ажиллагааны чиглэл болон эрх

³ Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ.

⁴ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

⁵ орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

зүйн баримт бичгүүдийн уялдаа хангагдаагүй байжээ. Харин аймгийн ИТХ-ын 2025 оны 34 дүгээр тогтоолоор байгууллагын дүрмийг шинэчлэн баталж, үндсэн үйл ажиллагааны чиг үүргийг өргөжүүлэн тодорхойлсны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг бүртгүүлснээр дээрх зөрчлийг арилгасан байна.

Сүүлийн 4 жилийн байдлаар “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь байгууллагын дүрэмд тусгагдсан болон улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн үндсэн үйл ажиллагааг чиглэлээр аливаа үйл ажиллагааг эрхлээгүй, орон нутгаас шилжүүлэн өгсөн эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний болон бэлчээр, тариалангийн тоног төхөөрөмж, хөрөнгүүд зориулалтын дагуу ашиглагдаагүй байна. Үүнд байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг бүрдүүлээгүй, өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх хэмжээний орлого олох үйл ажиллагааг тасралтгүй явуулж чадаагүй зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлжээ.

Аймгийн ИТХ-аас 2026 онд Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг дэмжихээр 150.0 сая төгрөгийн урсгал зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсантай холбоотойгоор байгууллагын ТУЗ-өөс бүтэц, орон тоог шинэчлэн тогтоож үйл ажиллагаа тасралтгүй явуулах боломжийг нь бүрдүүлж өгсөн байна.

Ингэснээр тус байгууллагын гүйцэтгэх удирдлага нь 2026 онд байгууллагын эзэмшлийн талбайд малын тэжээлийн эрдэнэ шиш, ногоон тэжээл зэргийг тариалж орон нутгийнхаа малчдад тээврийн зардалгүй суурь үнээр малын тэжээл борлуулах чиглэлээр 92.0 сая төгрөгийн 1 төсөл боловсруулж шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад, цөлжилттэй тэмцэх чиглэлээр Аймгийн Засаг дарга болон Байгаль орчны мэдээлэл, сургалт судалгааны төвтэй хамтран ажиллах олон талт гэрээг байгуулж “Цөлийн хөгжил” төслийг боловсруулан холбогдох олон улсын байгууллагуудад тус тус хүргүүлсэн байна.

1.2. Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ болон төрийн байгууллагын хооронд чиг үүргийн давхцал үүсээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13⁶ дугаар зүйлд заасны дагуу аймаг, сумын хүн амын нийтлэг хэрэгцээг хангах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зорилгоор орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг үүсгэн байгуулсан байна.

“Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2005 оны 01 дүгээр тогтоолоор ус хангамж, ариутгах татуурга, бохир ус цэвэрлэгээ, нийтийн халуун усны үйлчилгээ, дулаан хангамжийн шугам сүлжээний ашиглалт, засвар угсралтын чиглэлээр байгуулагдсан. Тус үйлдвэрийн газар дүрэмд заасан зорилт, чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ТУЗ-ийн шийдвэрээр батлагдсан бүтэц, орон тооны дагуу захиргаа, цэвэр ус, диспетчерийн, бохир ус зайлуулах, халуун усны үйлчилгээ, дулаан хангамж, цэвэрлэх байгууламжийн албадаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

⁶ Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна:

1/ төрийн байгууллага, албан газар;

2/төрийн өмчит нийтийн үйлчилгээний байгууллага;

3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг.

4/төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага.

5/төрийн болон орон нутгийн өмчит компани.

Эдгээр чиг үүрэг нь төрийн байгууллагын хэрэгжүүлдэг бодлого боловсруулах, зохицуулалт хийх, хяналт тавих чиг үүргээс ялгаатай бөгөөд нийтийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд чиглэсэн байна.

“Мандлын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ нь Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт хог хаягдлын үйлчилгээ үзүүлэх, гудамж талбайн цэвэрлэгээ, гэрэлтүүлгийн ашиглалт, ногоон байгууламжийн арчилгаа, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд аймгийн ИТХ-аас баталсан нэгж өртгийн тарифын дагуу дээрх үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэж, нийтийн эзэмшлийн талбайн хэвийн ашиглалт, цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламж болон гэрэлтүүлгийн үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

Харин Сайнцагаан сумын ЗДТГ-ын бүтэц, орон тооны мэдээллийг судлахад захирагчийн ажлын албанд ажиллаж буй гэрэлтүүлэг, ногоон байгууламж, орчны тохижилт, эрүүл ахуйн ажилтан болон хог хаягдлын олон нийтийн байцаагч нар нь хог хаягдал, тохижилтын асуудлаар үйлчилгээ үзүүлэх бус, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөн туслах, зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

“Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ нь Эрдэнэдалай суманд сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах, суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, хүүхдийн оюун ухаан, хэл яриа, бие бялдрыг хөгжүүлэх, орчин үеийн техник, технологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн их, дээд сургуульд элсэн суралцах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр байгуулагдсан. Тус байгууллага нь байгуулагдсанаас хойш дүрэмд заасан үндсэн чиг үүргийн хүрээнд сумын ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын хөгжлийг дэмжих, нэмэлт сургалт, хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Уг үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үндсэн сургалтын үйл ажиллагааг орлох бус, суралцагчийн хөгжлийг дэмжих, нэмэлт үйлчилгээ үзүүлэхэд чиглэж байгаа бөгөөд боловсролын байгууллагын үндсэн сургалтын чиг үүрэгтэй давхцахгүй байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ-ууд нь тухайн орон нутгийн иргэдийн тав тух, амьдрах орчныг сайжруулах зорилгоор ажил, үйлчилгээг шууд гүйцэтгэн хүргэх, харин төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд нь бодлого, зохицуулалт, зохион байгуулалт, хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 14.2.11⁷-т заасан өөрийн бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгавар, ХЭГ-ын даргын 2025 оны 123 дугаар тушаалыг тус тус үндэслэн нутгийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийх дэд ажлын хэсгийг байгуулжээ. Тус шинжилгээнд нутгийн захиргааны байгууллага буюу аймаг, сумдын ЗДТГ болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг судалсан боловч ОНӨААТҮГ-ыг дээрх хамрах хүрээнд оруулаагүй байна.

Үүний улмаас төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд болон төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардал, уялдаа холбоо, үр ашгийн талаарх иж бүрэн шинжилгээ хийгдээгүй байна.

⁷ төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;



БҮЛЭГ 2. ОНӨААТҮГ НЬ ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ТОДОРХОЙ ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙГАА БОЛОВЧ ЗАСАГЛАЛ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙГЭЭС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨ БҮРЭН ХАНГАГДАХГҮЙ БАЙНА.

2.1. ОНӨААТҮГ-уудын засаглал, хяналт, төлөвлөлт, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас үйл ажиллагааны үр нөлөө, ашигт ажиллагаа бүрэн хангагдахгүй байна.

ОНӨААТҮГ-уудын ТУЗ-ыг хуульд заасны дагуу томилсон боловч зөвлөлд өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх гишүүнийг томилоогүй байна.

Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийг томилох асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон ОНӨААТҮГ-ын дүрмээр тус тус зохицуулж байна.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор ОНӨААТҮГ-уудын удирдах зөвлөлийн гишүүдийг томилж, чөлөөлсөн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.1⁸, 21.5.2⁹, 21.5.3¹⁰ -т заасан шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулан томилсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.3¹¹ ТУЗ-д ажиллах орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилохоор зохицуулсан бөгөөд ОНӨААТҮГ-уудын ТУЗ-ыг байгуулсан ИТХ-ын тогтоолд аль гишүүн нь өмчийн төлөөлөгчийн ажлыг хариуцан хэрэгжүүлэх асуудлыг тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, 21.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Мөн өмчлөгчийн эрх, ашиг сонирхлыг ТУЗ-д төлөөлөх эрх, үүрэг, хариуцлагын хэрэгжилт тодорхойгүй болж, орон нутгийн өмчийн удирдлага, хяналт, тайлагналын үр нөлөө сулран, ТУЗ-ийн шийдвэр өмчлөгчийн бодлого, зорилттой нийцэхгүй байх, улмаар засаглалын үр ашиг буурч, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэл үүсэж байна.

Иймд ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийг байгуулах, өөрчлөн бүрдүүлэх тухай ИТХ-ын тогтоолд өмчийн төлөөлөгчөөр ажиллах гишүүнийг тодорхойлон тусгаж, түүний эрх, үүрэг, хариуцлага, тайлагналын шаардлагыг тодорхой болгох шаардлагатай байна. Дээрх асуудлаар аймгийн Засаг дарга болон Хулд сумын Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Мөн Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1¹² -д ТУЗ-нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд түүний үүрэг хариуцлагыг талаар зохицуулсан бөгөөд “Мөнх эрин ногоон говь” ОНӨААТҮГ-ын УЗ-ийн нарийн бичгийн даргыг тусгайлан томилоогүй байна.

Энэ нь удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэрийн бүртгэл, баримтжуулалт, хэрэгжилтэд тавих хяналт сулрах эрсдэлтэй тул ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилж, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон ТУЗ-ийн үйл ажиллагааны зохион байгуулалт, баримтжуулалтыг хэвшүүлэх талаар Хулд сумын Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

⁸ тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай;

⁹ тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх;

¹⁰ төрийн захиргааны албан хаагч болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээдийн ажилтан байх.

¹¹ Орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах;

¹² Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөлд томилно.

Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилт, мэдээллийн хангалтыг бүрэн хангаагүй, ТУЗ-ийн хяналт сул байснаас шийдвэрийн үр нөлөө хангалтгүй байна.

ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх удирдлага нь байгууллагын үйл ажиллагааг өдөр тутам удирдан зохион байгуулж, ТУЗ-ийн шийдвэр, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, хөрөнгө, санхүү, хүний нөөцийг үр ашигтай удирдаж, үр дүнг ТУЗ-д тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Харин ТУЗ нь жилийн орлого, зардлын тооцоог хянаж, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэж батлах, гүйцэтгэлийг үнэлэх, шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, тэмдэглэл гаргаж, дарга гарын үсэг зурж баталгаажуулахаар дүрэмд заажээ.

Гэвч аймгийн ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийг санхүүгийн гүйцэтгэл, ашигт ажиллагааны тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, үйл ажиллагааны тайлан, түүний хэрэгжилт болон дүрэмд тусгагдсан шаардлагатай мэдээллээр хангах чиг үүргээ 2025, 2026 онд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Мөн ОНӨААТҮГ-уудын ТУЗ-өөс дүрэм заасан чиг үүргийн хүрээнд гаргасан шийдвэрийг баталгаажуулах, түүний хэрэгжилтийг үнэлэх, хянах ажил хангалтгүй байна. Тухайлбал;

- ОНӨААТҮГ-уудын ТУЗ -нь 2025, 2026 онд байгууллагын жилийн орлого, зардлын тооцоог хянаж, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх, хянах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй.
- “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын хувьд 2026.06.04-ний өдөр ТУЗ-ийн хурлаар үндсэн 75, машинист 48 буюу нийт 123 орон тооны бүтэц болон 2026 оны орлого, зардлын төлөвлөгөөг хэлэлцсэн боловч УЗ-ийн дарга эзгүй шалтгаанаар эцсийн шийдвэрийг гаргаж, тогтоолоор баталгаажуулаагүй.
- Дэрэн сумын “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын хувьд 2025.12.25-ны өдрийн № 02 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц, орон тоо, цалингийн санг баталсан боловч 2023-2025 оны санхүүгийн төлөвлөгөө болон жилийн орлого, зардлын тооцоог хэлэлцэж батлаагүй.
- “Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ-ын ТУЗ - нь 2026 онд огт хуралдаагүй бөгөөд 2023-2025 оны жилийн орлого, зардлын тооцоог хянаж, санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцэн батлаагүй байна. ТУЗ-өөс зөвхөн ажилтнуудын цалин нэмэгдүүлэх, гүйцэтгэх захирлын цалинг тогтоох асуудлаар хуралдсан боловч үйл ажиллагааны орлогыг хэрхэн нэмэгдүүлэх бодит төлөвлөгөөг хянах, батлах талаар хуралдаж баталсан тогтоол байхгүй байна. Мөн “Мөнх эрин ногоон говь” ОНӨААТҮГ-ын ТУЗ нь 2025-2026 онд 1 удаа хуралдаж бүтэц, орон тоог хэлэлцэн баталсан ч санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцэн батлаагүй байна.

Энэ нь ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөлт, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт, мэдээллээр хангах, санхүүгийн төлөвлөлт, төсөв батлуулах болон ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын эрх, үүргийн хэрэгжилт хангалтгүй байсантай холбоотой байна.

Мөн ТУЗ-өөс байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, шийдвэрийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээр батлагдсан төлөвлөгөөгүй ажиллах, шийдвэрийн хэрэгжилт, хариуцлага тодорхойгүй болох, ашигт ажиллагаа буурч төсвийн хамаарал нэмэгдэх, улмаар засаглал, ил тод байдал, хариуцлагын тогтолцооны үр нөлөө сулрах нөхцөл бүрдсэн байна.

Иймд ОНӨААТҮГ - нь ТУЗ-ийг шаардлагатай мэдээллээр бүрэн хангаж, ТУЗ нь үйл ажиллагаагаа идэвхжүүлж, хуралдааныг дүрмийн дагуу тогтмол зохион байгуулж, үр дүнтэй

ажиллаж байгууллагын ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх асуудлаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.


2.2. ОНӨААТҮГ-үүд нь орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа боловч санхүүгийн тогтвортой байдал, бие даасан байдал хангалтгүй байна.

ОНӨААТҮГ-үүд нь нийтийн үйлчилгээ үзүүлж байгаа боловч төсвийн санхүүжилтийн хамаарал, алдагдал, зарим байгууллагын өр төлбөр өндөр байгаа нь орон нутгийн санхүүд ачаалал үүсгэж байна.

Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-уудын санхүүгийн байдлыг 2023-2025 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд үндэслэн шинжлэхэд ашигт ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдал, төсвийн санхүүжилтээс хамаарах байдал харилцан адилгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт № 1 -ээр харна уу.)

Аймгийн ОНӨААТҮГ-уудын нийт орлого 2023-2025 онуудад 3,212.2 - 7,425.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс авсан санхүүжилт нь 2023 онд 1,374.4 сая төгрөг байсан бол 2025 онд 2,911.9 сая төгрөгт хүрч, 2.1 дахин өссөн бөгөөд төсвөөс авсан санхүүжилт, нийт орлогын харьцаа 2023-2025 онуудад 42.8- 38.9 хувийг бүрдүүлж байна.

График № 1 /Аймгийн ОНӨААТҮГ-уудын нийт орлого, санхүүжилтийн харьцаа /



Байгууллага тус бүрээрх төсвөөс авсан санхүүжилт, орлогын харьцааг хүснэгтээр харуулбал дараах байдалтай. “Мандалын гэгээ” хот тохижуулах газар 2023 онд орон нутгийн төсвөөс 919.5 сая төгрөгийн санхүүжилт авч байсан бол 2025 онд 2,299.2 сая төгрөгт хүрч, нийт орлогын 89.7 хувийг төсвийн татаас, санхүүжилтээс бүрдүүлсэн; “Дундговь-Ус” ОНӨААТҮГ 2023-2025 онд 445.4-720.0 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт орлогын 9.5-20.6 хувийг төсвийн татаас, санхүүжилтээс бүрдүүлсэн байна. Мөн “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ 2024-2025 онд 166.1-175.4 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт орлогын 87.6-95.4 хувийг төсвийн татаас, санхүүжилтээр бүрдүүлсэн бол “Эрдэм шинжилгээ, туршилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ 2023-2025 онд төсвийн татаас, санхүүжилт аваагүй бөгөөд 2026 оны 6 дугаар сарын байдлаар 82.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт № 2 /ОНӨААТҮГ-уудын нийт орлого, санхүүжилтийн харьцааны мэдээлэл/ сая төгрөг

		2023 он	2024 он	2025 он
“Дундговь-Ус”	Нийт орлого	2,234.5	3,491.5	4,698.4
	Төсвөөс авсан санхүүжилт	454.9	720.0	445.4
	Харьцаа	20.4%	20.6%	9.5%

“Мандалын гэгээ” (Хот тохижуулах газар)	Нийт орлого	977.8	1,577.6	2,561.9
	Төсвөөс авсан санхүүжилт	919.5	1,447.5	2,299.2
	Харьцаа	94.0%	91.8%	89.7%
“Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”	Нийт орлого	-	166.1	175.4
	Төсвөөс авсан санхүүжилт		145.6	167.3
	Харьцаа		87.6%	95.4%
“Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээ”	Нийт орлого	-	-	23.0
	Төсвөөс авсан санхүүжилт	-	-	-
	Харьцаа	-	-	0.0%
"Мөнх эрин ногоон говь" (Хулд сумын ОНӨААТҮГ)	Нийт орлого	-	-	29.8
	Төсвөөс авсан санхүүжилт	-	-	-
	Харьцаа	-	-	0.0%
Нийт ОНӨААТҮГ-ын дүн	Нийт орлого	3,212.2	5,235.2	7,488.5
	Төсвөөс авсан санхүүжилт	1,374.4	2,313.1	2,911.9
	Харьцаа	42.8%	44.2%	38.9%

ОНӨААТҮГ-ууд нь аж ахуйн тооцооны зарчимд тулгуурлан өөрийн орлогоор үйл ажиллагаагаа санхүүжүүлэх үүрэгтэй боловч зарим байгууллагын орлогын 87.6-95.4 хувийг орон нутгийн төсвийн татаас, санхүүжилт бүрдүүлж байгаа нь орон нутгийн өмчид тулгуурлан орлого олох, санхүүгийн бие даасан байдлыг хангах хуулийн шаардлага бүрэн хангагдахгүй, төсвийн санхүүжилтээс өндөр хамааралтай ажиллаж байгааг харуулж байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хасаж тооцсон дүнгээр ОНӨААТҮГ - ууд 2025 онд нийт дүнгээрээ 233.0 сая төгрөгийн алдагдалтай байна.

График № 2 /Аймгийн ОНӨААТҮГ-уудын ашиг, алдагдал/

Харин байгууллагын хувьд авч үзвэл: “Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ 2025 онд 233.5 сая төгрөгийн ашигтай, “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ 7.3 сая төгрөгийн ашигтай ажилласан бол “Дундговь-Ус” ОНӨААТҮГ 475.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, “Эрдэм шинжилгээ, туршилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ 2023-2025 онд төсвийн санхүүжилт аваагүй хэдий ч жил бүр 0.1-29.1 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

ОНӨААТҮГ-ууд орон нутгийн төсвөөс татаас, санхүүжилт авч байгаа боловч орлого бүрдүүлэлт, зардлын удирдлага, үйл ажиллагааны үр ашиг хангалтгүй, алдагдалтай ажиллаж байгаа нь аж ахуйн тооцоо, өөрийгөө санхүүжүүлэх зарчмын хэрэгжилт сул байгааг илэрхийлж байна.

ОНӨААТҮГ-уудын 2023-2025 оны богино хугацаат өр төлбөр 419.6- 1,407.1 сая төгрөг болж өмнөх оноос 47.1 хувиар буюу 450.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.




График № 3 /Аймгийн ОНӨААТҮГ-уудын богино хугацаат өр, төлбөр/



Өр, төлбөрийн 99.6 хувийг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-аарын өр эзэлж байгаа бөгөөд 2025 оны өр төлбөр дансны үлдэгдэл 1,401.8 сая төгрөг болж өмнөх оноос 478.1 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс НӨАТ-ын өглөг 352.9 сая төгрөг, ХХОАТ-ын өглөг 235.1 сая төгрөг, НДШ-ийн өглөг 117.3 сая төгрөг, нүүрсний дансны өглөг 693.2 сая төгрөг байна. Өр төлбөр өмнөх оноос 51.8 хувиар өссөн нь халаалтын зуухны засвар үйлчилгээ, эвдрэл гэмтлийн улмаас орлогоо бүрэн төвлөрүүлж чадаагүй, ажиллах

хүчний зардал нэмэгдсэнээр татвар, НДШ-ийн өглөг үүссэн, мөн сэлбэг хэрэгслийн өглөг өссөнтэй холбоотой бөгөөд энэ нь байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулах эрсдэлтэй тул мөнгөн хөрөнгийн урсгалыг сайжруулж, өр авлагыг барагдуулах шаардлагатай байна.

Мөн 2025 онд 475.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласны зэрэгцээ богино хугацаат өр төлбөр нь 1,401.8 сая төгрөгт хүрч өмнөх оноос 51.8 хувиар өссөн нь байгууллагын мөнгөн хөрөнгийн урсгал, төлбөрийн чадвар муудаж, үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдалд эрсдэл үүссэнийг харуулж байна. Дээрх асуудлаар тус газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн байна. Бусад ОНӨААТҮГ - уудын хувьд 2025 оны жилийн эцсийн байдлаар 0.2-4.2 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

Урт хугацаат өр төлбөрийн хувьд “Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь АХБ-ны Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн үйлчилгээг хөгжүүлэх II шатны төслийн хүрээнд авсан урт хугацаат валютын зээлтэй бөгөөд 2025 оны эцэст зээлийн үлдэгдэл 11,695.8 сая төгрөг байна. Сүүлийн 3 жилд үндсэн зээлд 1,739.2 сая төгрөг, хүүгийн төлбөрт 2,678.9 сая төгрөг, нийт 4,418.1 сая төгрөгийн төлбөр хийгдсэн боловч валютын ханшийн зөрүүнээс шалтгаалан зээлийн үлдэгдэл төдийлөн буураагүй бөгөөд 2025 онд ханшийн зөрүүний улмаас зээлийн үлдэгдэл 522.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 3 /Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын урт хугацаат валютын зээлийн мэдээлэл/ сая төгрөг

Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он
Урт хугацаат валютын зээлийн үлдэгдэл	15,075.9	11,173.5	11,695.8
Валютын зээлийн ханшийн зөрүүний өөрчлөлт		(3,902.4)	522.3
Зээлийн үндсэн төлбөр төлөлт	461.2	214.0	1,064.0
Хүүгийн төлбөр төлөлт	1,479.3	629.0	566.9
Нийт төлөлт	1,940.6	843.0	1,630.9

Тус байгууллага зээлийн төлбөрийг өөрийн үйл ажиллагааны орлогоос төлж барагдуулах санхүүгийн чадавхгүй байгаа тул хуваарьт үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн төлж байгаа нь орон нутгийн төсөвт тогтмол ачаалал үүсгэж, тухайн эх үүсвэрийг бусад хөгжлийн болон хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулах боломжийг хязгаарлаж байна.

Түүнчлэн валютын ханшийн өсөлтөөр зээлийн үлдэгдэл нэмэгдэж, байгууллагын санхүүгийн чадавх сул байгаатай холбоотойгоор урт хугацаат зээлийн төлбөрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх шаардлага үргэлжилж, төсвийн дарамт болон ирээдүйд үүсэх санхүүгийн эрсдэл өсөн нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

Иймд байгууллагын орлого, мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх, авлага барагдуулах арга хэмжээг эрчимжүүлэхийн зэрэгцээ валютын зээлийн эрсдэлийг үнэлж, зээлийн нөхцөл болон ханшийн эрсдэлийг бууруулах боломжит хувилбаруудыг холбогдох байгууллагуудтай хамтран судалж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээрх асуудлаар аймгийн “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар УАГ-аар дамжуулан СЯ-нд санал хүргүүлж, “ТЕЗ-ийн 2025 оны төсвийн төсөл орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагын бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашигт”-т хийсэн нийцлийн аудитаар ТЕЗ-д зөвлөмж хүргүүлсэн байна.

ОНӨААТҮГ-уудын санхүүгийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээгээр байгууллагуудын ашигт ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдал харилцан адилгүй байгаа бөгөөд зарим байгууллага төсвийн санхүүжилтээс хамааралтай, зарим нь өр төлбөр, хуримтлагдсан алдагдлын дарамттай ажиллаж байна. Ялангуяа “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын өр төлбөр эрс өсөж санхүүгийн эрсдэл нэмэгдсэн бол “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”, “Эрдэм шинжилгээ, туршилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ууд алдагдалтай ажиллаж, харин “Мандалын гэгээ хот тохижуулах газар” ОНӨААТҮГ төсвөөс олгосон санхүүжилтийн үр дүнд ашигтай ажилласан байна.

Аудитын явцад “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын 2024, 2025 оны санхүүгийн тайланд хийсэн шинжилгээний дүнгээр үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн байдал өмнөх оноос сөргөөр өөрчлөгдсөн байна. Эргэлтийн болон түргэн хөрвөх харьцаа буурч, богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадвар сулран, төлбөрийн чадварын эрсдэл нэмэгдсэн байна. Өр төлбөрийн харьцаа өмнөх онтой адил түвшинд байгаа боловч ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сөрөг хэвээр бөгөөд цэвэр ашгийн түвшин, хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж буурсан нь үйл ажиллагаа алдагдалтай, хөрөнгө болон өөрийн хөрөнгийн ашиглалтын үр ашиг хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт № 4 /Дундговь- Ус ОНӨААТҮГ-ын санхүүгийн шинжилгээ/

сая төгрөг

Балансын үзүүлэлт	2024	2025
Хөрвөх чадварын харьцаа		
Эргэлтийн харьцаа: Эргэлтийн хөрөнгө / Богино хугацаат өр төлбөр	1.32	0.78
Түргэн эргэлтийн харьцаа: (Эргэлтийн хөрөнгө - Бараа материал) / Богино хугацаат өр төлбөр	0.40	0.29
Өр төлбөрийн харьцаа		
Өрийн харьцаа: Нийт өр төлбөр / Нийт хөрөнгө.	0.26	0.26
Өр ба өөрийн хөрөнгийн харьцаа: Нийт өр төлбөр / Өөрийн хөрөнгө.	0.36	0.36
Ашигт ажиллагааны харьцаа		
Цэвэр ашгийн хувь: Цэвэр ашиг / Нийт борлуулалт.	(0.48)	(0.57)
Нийт хөрөнгийн өгөөж : Цэвэр ашиг / Нийт хөрөнгө.	(0.04)	(0.05)

Өөрийн хөрөнгийн өгөөж : Цэвэр ашиг / Өөрийн хөрөнгө.

(0.05)

(0.07)

Өр төлбөр, авлагын өсөлтөөс шалтгаалан төлбөрийн чадвар сулрах, үйл ажиллагааны тасралтгүй байдал алдагдах, татвар болон нийгмийн даатгалын өрөөс үүдэлтэй эрсдэл нэмэгдэхийн зэрэгцээ алдагдал хуримтлагдан өөрийн хөрөнгө багасах, хөрөнгө оруулалт болон үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж хязгаарлагдах, төсвийн санхүүжилтээс хамаарал нэмэгдэх, хөрөнгийн шинэчлэл удаашрах, улмаар орон нутгийн өмчийн үр ашиг, өгөөж буурах сөрөг үр дагавар үүсэхээр байна.

Иймд ОНӨААТҮГ-ууд нь орлого, ашигт ажиллагааг нэмэгдүүлж, өр авлагыг бууруулах, хөрөнгө, мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, орлогын эх үүсвэрээ төрөлжүүлэхийн зэрэгцээ өмчлөгчийн зүгээс санхүүгийн тогтвортой байдал, өөрийгөө санхүүжүүлэх зарчмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавих шаардлагатай байна.

Орон нутгийн өмчийн ашиглалтын үр өгөөжийн хувьд “Эрдэм шинжилгээ, туршилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-нь байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 329.5 сая төгрөгийн 62 ширхэг үндсэн хөрөнгүүд нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон бөгөөд гүйцэтгэх удирдлага, ТУЗ нь хөрөнгийн шинж байдлын талаарх дүгнэлт гаргах, түүнийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх асуудлаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь байгууллагын удирдлага удаа дараа солигдож үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдсан, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналт сулран зарим хөрөнгө эзэнгүйдсэн, мөн сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт хийгдээгүйтэй холбоотой байна.

Иймд ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомж болон Аймгийн ИТХ-ын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан **“Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах шилжүүлэх”** журмын дагуу шийдвэрлүүлэх талаар “Эрдэм шинжилгээ, туршилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын даргад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Цаашид өмч хөрөнгийн элэгдэл, эвдрэл нэмэгдэж ашиглалтын үр өгөөж буурах, хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдах, байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдал, үйлчилгээний чанар доройтох эрсдэлтэй тул өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалт, ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд ОНӨААТҮГ-ын даргыг томилсон эрх бүхий этгээд түүнтэй, байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин, техник, технологийг шинэчлэх даалгавар, менежментийн бодлого, цалин, нэмэгдэл хөлс, ажлын нөхцөл, эд хөрөнгийн хариуцлага зэрэг асуудлаар гэрээ байгуулж гүйцэтгэлийн үнэлж дүгнэх асуудлыг зохицуулсан байна.

Дундговь аймгийн Засаг даргаас 2024-2026 онуудад ОНӨААТҮГ-уудын дарга нартай, хуульд тусгагдсан эрх, үүргийн хэрэгжилт түүнтэй уялдуулан төсвөөс санхүүжилт олгохтой холбоотой гүйцэтгэл, үр дүнгийн гэрээ байгуулсан боловч хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.

Энэ нь байгууллагын удирдлагын үр дүн, хариуцлагыг бодитой үнэлэх боломж хязгаарлагдах, эдийн засгийн үр ашиг, үйл ажиллагааны зорилт, хөрөнгийн ашиглалт, менежментийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт сулрах, үр дүнгүй үйл ажиллагаанд

хариуцлага тооцох болон үр дүнтэй менежментийг урамшуулах механизм хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Тухайлбал: Дундговь-Ус ОНӨААТҮГ -т 2025 онд орон нутгийн төсвөөс 6,232.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 445.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон боловч санхүүгийн тайлан алдагдалтай, 1,401.8 сая өр төлбөртэй гарсан байна.

Иймд ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлагаас гэрээний хэрэгжилтийн тайланг гэрээнд заасан хугацаанд гаргуулан авч гэрээний хэрэгжилтийг тогтмол үнэлж дүгнэн, дүгнэлтийн мөрөөр холбогдох хариуцлага, урамшуулал болон менежментийн шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах асуудлаар Аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ОНӨААТҮГ-ууд нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна.

ОНӨААТҮГ -ууд нь байгууллагын хөрөнгө, төсвийн эх үүсвэрээс бусдад хандив, тусламж олгохыг Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10¹³, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3¹⁴ дахь заалтаар хориглосон шаардлагыг мөрдөж, аудитад хамрагдсан хугацаанд хандив, тусламж олгоогүй байна.

ОНӨААТҮГ-ууд байгууллагын үндсэн чиг үүрэг, дүрэм, санхүүгийн боломж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 2023-2025 онд нийт 617.8 сая төгрөгийн татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 207 ажлын байрыг бий болгож дараах хэлбэрээр орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулжээ. Тухайлбал:

- “Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь 2025 онд 56 төсвийн байгууллага, 198 аж ахуйн нэгж, 2,467 айл өрхийг цэвэр усаар хангаж, 16 төсвийн байгууллага, 61 аж ахуйн нэгж, 1,070 айл өрхөд дулаан түгээж, мөн гэр хорооллын 7,400 айл өрхөд 17 ус түгээх байраар үйлчилгээ үзүүлэн нийтийн аж ахуйн үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж байна.
- “Мандалын гэгээ” хот тохижуулах газар нь 2025 онд 207 аж ахуйн нэгж, байгууллага, 4,768 өрх, 32 хогийн бункерээс 122.9 мянган тонн хог хаягдал тээвэрлэн төвлөрүүлж, 1,042 гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг ханган, 210 га талбайн 273.0 мянган модны арчилгаа, усалгаа хийж, 46 км зам талбайн арчилгаа, цэвэрлэгээ, 1,890.2 м² замын нөхөөс болон тоглоомын талбайн засварын ажил гүйцэтгэсэн байна.
- “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ нь 2025 онд 12.0 сая төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлж, хүүхэд хөгжил, боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн сургалт, хөтөлбөрт 180 хүүхэд, иргэнийг хамруулан, сар бүр 25-35 сурагчийн сурлагын чанарыг дунджаар 30 хувиар ахиулж, автомат тоглоомын төв болон чөлөөт цагийн талбайгаар 3,700 гаруй хүүхдэд үйлчилгээ үзүүлэн хүүхдийн хөгжил, хамгаалал, нийгмийн оролцоог дэмжсэн байна.

Дээрх байдлаас дүгнэхэд Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ-ууд нь орон нутгийн санхүүд тодорхой үр өгөөж бий болгохын зэрэгцээ иргэдийн амьдрах орчны чанар, нийтийн үйлчилгээний хүртээмж, хүүхдийн хөгжил, дэд бүтцийн найдвартай байдал, байгаль орчны хамгаалал, хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих замаар нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн орон нутгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулж байна.

¹³ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.

¹⁴ Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- ✓ Аймаг, сумын ИТХ-аас ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, засаглалын талаар хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалт нь холбогдох хууль, журмын шаардлагад нийцэж байна.
- ✓ “Мөнх эрин ногоон говь” ОНӨААТҮГ-ыг орон нутгийн өмчийн оролцоог бүрдүүлэхгүйгээр байгуулсан нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцээгүй байна.
- ✓ Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ болон төрийн байгууллагын хооронд чиг үүргийн давхцал үүсээгүй байна.
- ✓ ОНӨААТҮГ-уудын ТУЗ-ыг хуульд заасны дагуу томилсон боловч зөвлөлд өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх гишүүнийг томилоогүй байна.
- ✓ Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилт, мэдээллийн хангалтыг бүрэн хангаагүй, ТУЗ-ийн хяналт сул байснаас шийдвэрийн үр нөлөө хангалтгүй байна.
- ✓ ОНӨААТҮГ-ууд нь нийтийн үйлчилгээ үзүүлж байгаа боловч төсвийн санхүүжилтийн хамаарал, алдагдал, зарим байгууллагын өр төлбөр өндөр байгаа нь орон нутгийн санхүүд ачаалал үүсгэж байна.
- ✓ ОНӨААТҮГ-ууд нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. ОНӨААТҮГ-уудын ТУЗ-ийг байгуулах, өөрчлөн бүрдүүлэх тухай ИТХ-ын тогтоолд өмчийн төлөөлөгчөөр ажиллах гишүүнийг нэр заан тодорхойлж, түүний эрх, үүрэг, хариуцлага, тайлагналын шаардлагыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тодорхой тусгуулах;
2. ОНӨААТҮГ-ын дарга нартай байгуулсан гүйцэтгэл, үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг тогтмол үнэлж дүгнэн, дүгнэлтийн мөрөөр холбогдох хариуцлага, урамшуулал болон менежментийн шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах;

Хулд сумын Засаг даргад:

1. Мөнх эрин ногоон говь ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүүгийн бие даасан байдлыг хангах зорилгоор хуульд нийцүүлэн шаардлагатай эд хөрөнгийг орон нутгийн өмчөөс шилжүүлэн эзэмшүүлэх, өмчийн бүртгэлд тусган баталгаажуулах асуудлыг сумын ИТХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх;
2. ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийг байгуулах, өөрчлөн бүрдүүлэх тухай ИТХ-ын тогтоолд нарийн бичгийн дарга болон өмчийн төлөөлөгчөөр ажиллах гишүүнийг нэр заан тодорхойлж, түүний эрх, үүрэг, хариуцлага, тайлагналын шаардлагыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тодорхой тусгуулах;

Аймгийн ОНӨААТҮГ-ууд Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөлт, шийдвэр гаргалт, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт, мэдээллийн хангалт, санхүүгийн төлөвлөлт болон ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын эрх, үүргийн хэрэгжилтийг сайжруулж, байгууллагын ашигт ажиллагаа, засаглалын үр нөлөөг нэмэгдүүлэх;

Аймгийн ОНӨААТҮГ-дын гүйцэтгэх удирдлагад:

1. Жилийн орлого, зардлын тооцоо, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг бодитой боловсруулан ТУЗ-аар батлуулж, үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхийн зэрэгцээ санхүү, үйл ажиллагааны мэдээллээр ТУЗ-ийг тогтмол ханган, ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;
2. Орлого нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг сайжруулах, өр авлагыг бууруулах, хөрөнгө болон мөнгөн хөрөнгийн ашиглалтыг үр ашигтай удирдах, орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх чиглэлээр бодитой төлөвлөлт боловсруулж хэрэгжилтийг ханган санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэх.



Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211 тоот, 7 дугаар баг,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090 Утас: 7059 2353
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2026.09.17 № 01/1389

танай _____-ны № _____-т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төв)-ийн болон Төрийн байгууллага хоорондын чиг үүргийн давхцал, үр нөлөө”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал тайлбар байхгүй болно.



С.МӨНХЧУЛУУН

4826240615

Хавсралт № 1

Аймгийн ОНӨААТҮГ-дын санхүүгийн балансын үзүүлэлтүүд 2023-2025 он (сая төгрөгөөр)

ОНӨААТҮГ-ын нэрс	Үзүүлэлтүүд	2023 он	2024 он	2025 он	
“Дундговь-Ус”	Авлага	269.9	324.9	363.7	
	Богино хугацаат өр төлбөр	415.3	923.6	1,401.8	
	Үндсэн хөрөнгө	33,402.1	44,474.3	48,547.4	
	ҮХ-ийн элэгдлийн зардал	1,220.1	1,635.3	2,180.9	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	(1,682.4)	(1,666.4)	(2,656.2)	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал***/	(462.3)	(31.1)	(475.3)	
	Төсвөөс авсан санхүүжилт	454.9	720.0	445.4	
“Мандалын гэгээ” (Хот тохижуулах газар)	Авлага	13.9	9.0	14.8	
	Богино хугацаат өр төлбөр	0.1	28.9	0.2	
	Үндсэн хөрөнгө	10,963.7	10,883.8	10,977.3	
	ҮХ-ийн элэгдлийн зардал	1,392.7	1,450.2	1,589.4	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	(1,456.5)	(1,514.4)	(1,355.9)	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал***/	(63.8)	(64.2)	233.5	
	Төсвөөс авсан санхүүжилт	919.5	1,447.5	2,299.2	
“Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв”	Авлага	-	-	-	
	Богино хугацаат өр төлбөр	-	-	0.9	
	Үндсэн хөрөнгө	-	475.7	1,095.2	
	ҮХ-ийн элэгдлийн зардал	-	70.9	71.7	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	-	16.5	(64.4)	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал***/		87.4	7.3	
	Төсвөөс авсан санхүүжилт	-	145.6	167.3	
“Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээ”	Авлага	20.2	20.2	20.2	
	Богино хугацаат өр төлбөр	4.2	4.2	4.2	
	Үндсэн хөрөнгө	436.3	423.5	410.6	
	ҮХ-ийн элэгдлийн зардал	12.8	12.8	12.8	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	(41.9)	(12.8)	(12.9)	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал***/	(29.1)	-	(0.1)	
	Төсвөөс авсан санхүүжилт	-	-	-	
"Мөнх эрин ногоон говь" (Хулд сумын ОНӨААТҮГ)	Авлага	-	-	0.0	
	Богино хугацаат өр төлбөр	-	-	-	
	Үндсэн хөрөнгө	-	-	-	
	ҮХ-ийн элэгдлийн зардал	-	-	-	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	-	-	1.6	
	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал***/			1.6	
	Төсвөөс авсан санхүүжилт	-	-	-	

Татварын дараах цэвэр ашиг /алдагдал***/- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хасаж тооцов.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН